

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын
2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/133/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
	4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	12
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
	4.5 Аудит хийсэн Зорилтот түвшний биелэлт	18

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ Г
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Р.БУД
ТАНАА

2018.03.15 № 06/478
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын захирал Р.Буд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн харилцагч байгууллагуудаас авах авлагын үлдэгдлийг “Тооцооны үлдэгдлийн баталгаа”-аар баталгаажуулж авлагыг барагдуулж ажиллах, Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа эргэлтийн сүргийн мал амьтадын нас дэвшилтийг тооцож тооллого бүртгэлийг хийх, Үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 21-нээс 2019 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн Аудитор А.Гэрэлмаа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэхээр, Ахлах аудитор Д.Товуудорж, Аудитор Д.Туяа, Аудитор Э.Отгонзаяа, Шинжээч С.Наранцэцэг нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг, тодруулгын хамт “Мэдээлэл-Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 1/117 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Зам, тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэлд нэвтрүүлэх, салбарын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Авто зам, тээврийн талаар гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, авто замын сүлжээний ашиглалт, зураг төслийн магадлал, эрдэм шинжилгээ, норм норматив, инновацын үйл ажиллагааг боловсруулах, замын байгууламжийн барилга засварын ажлын техник технологийн хяналт хийх.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Компаний тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай багц хууль
- Татварын тухай багц хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Авто замын тухай хууль
- Барилгын тухай хууль

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль эрх зүйн орчны хувьд томоохон өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирлын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/73 тоот тушаалын дагуу мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус төвийн орлого төлөвлөгддөг ба зардал нь удирдлагын шийдвэрээр гардаг тул нарийвчлан хянаж, эрсдэлтэй гэж үзлээ.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны Нийт зардал 2,172.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 43.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Үзүүлсэн ажил үйлчилгээний өртөг /6109/ дансанд үйл ажиллагааны бус 21.6 сая төгрөгийн зардлыг бүртгэн үйл ажиллагааны үр дүнг буруу тайлагнасан.
- Тайлант хугацаанд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар тус төвийн "Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ"-тэй 3 газрын үнэлгээ 815.3 сая төгрөгийг "Эздийн өмчийн бусад хэсэг" дансанд бүртгээгүй.
- "Авто замын тоног төхөөрөмжийн түрээс" ТӨХК-с балансаас балансад шилжиж ирсэн өмчийн хэсэг 69.3 сая төгрөгийг "Төрийн өмч" дансанд бүртгэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(Сая төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	32.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1.9	
3	Албан шаардлага өгсөн	1	0	
	Дүн	5	34.6	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Татварын ерөнхий газрын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/2653 тоот албан бичигт "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 6.2-д заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байгаад албан шаардлага өгөх,
2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 244 дүгээр тушаал болон ТӨБЗГ-ын 2018 оны 12 сарын 06-ны өдрийн А-4/4578 тоот албан бичгийн дагуу ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Нямдаваад гадаад томилолтын зардал 1.9 сая төгрөгийг олгосонд төлбөрийн акт тогтоосон.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2018 оны батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу төлөвлөгөөний гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Зорилтот түвшингийн тодотгосон төлөвлөгөөгөөр 2,409.7 сая төгрөгийн орлоготой, 2,390.2 сая төгрөгийн зардалтай, 19.5 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн хэдий ч 2,728.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 113 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийт зардлыг 2,390.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 88 хувиар буюу 2,106.6 сая төгрөгийг зарцуулж, татварын өмнөх ашгийг давуулан биелүүлсэн нь орлогыг 13 хувиар давуулан биелүүлсэн, зардлыг 12 хувиар хэмнэснээс шалтгаалсан байна.

Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 143 мэдээлэл байршуулахаас 143 мэдээлэл байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа 0.9 сая төгрөгийн үнэ бүхий Эргэлтийн сүргийн мал амьтадын нас дэвшилтийг тооцоогүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “оршин байх”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл зөрчигдөх
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах "* гэсэн заалтыг мөрдөн ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оны 4-р сарын 30-ний дотор өөрчлөлтийг бүртгэж хариу мэдэгдэнэ.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

Тавилга эд хогшил дансанд 4-н нэр төрлийн 6.4 сая төгрөгийн компьютер, техник хангамжийг дансны ангилал буруу бүртгэсэн.

3.2.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл зөрчигдөх
- НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” зөрчигдөх
- НБББББичиг мөрдөгдөхгүй байх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандартыг мөрдөх, НБББББ-ийн дагуу хөрөнгийн ангилалыг бүртгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оны 4-р сарын 30-ний дотор хөрөнгийн ангилалыг зөв бүртгэж хариу мэдэгдэнэ.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нийт авлагын үлдэгдлийн 6% буюу 23 харилцагчийн 25.4 сая төгрөгийг “Тооцооны үлдэгдлийн баталгаа”-аар баталгаажуулаагүй.

3.3.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдэл зөрчигдөх
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20.2.6-д *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэсэн заалтыг мөрдөн ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оны 4-р сарын 30-ны дотор хэрэгжүүлж хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,219,701,418.03	1,514,999,707.92
1.1.2	Дансны авлага	54,085,368.28	414,450,656.35
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		237,809.89
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	123,665,444.85	172,947,809.99
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,060,000.00	8,100,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		900,000.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,409,512,231.16	2,111,635,984.15
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,795,418,585.58	3,783,522,332.92
1.2.2	Биет бус хөрөнгө	2,067,900.07	820,580,799.91
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,797,486,485.65	4,604,103,132.83
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,206,998,716.81	6,715,739,116.98
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		194,283,529.30
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	10,719,829.77	62,069,966.02
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		

2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,719,829.77	256,353,495.32
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,118,063,314.62	1,073,601,650.70
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,118,063,314.62	1,073,601,650.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,128,783,144.39	1,329,955,146.02
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,012,811,105.36	1,012,811,105.36
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		870,556,471.43
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		884,650,940.71
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,065,404,467.06	2,617,765,453.46
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,078,215,572.42	5,385,783,970.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,206,998,716.81	6,715,739,116.98

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,737,647,877.37	2,638,077,042.84
2	Борлуулалтын өртөг	1,621,856,708.04	1,979,727,170.49
3	Нийт ашиг(алдагдал)	115,791,169.33	658,349,872.35
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	22,779,952.65	36,614,213.91
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		48,824,491.20
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	31,372,825.00	83,988,917.28
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	14,847,702.00	42,923,737.78
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		4,500,000.02
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	92,350,594.98	621,375,922.42
19	Орлогын татварын зардал	10,719,829.77	66,069,966.02
20	Татварын дараах ашиг (алдагдал)	81,630,765.21	555,305,956.40
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	81,630,765.21	555,305,956.40
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	81,630,765.21	555,305,956.40
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,064,339,806.08						1,980,811,545.57	3,045,151,351.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							2,962,156.28	2,962,156.28
3	Залруулсан үлдэгдэл	1,064,339,806.08						1,983,773,701.85	3,048,113,507.93
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							81,630,765.21	81,630,765.21
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт	- 51,528,700.72							- 51,528,700.72
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,012,811,105.36						2,065,404,467.06	3,078,215,572.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							- 2,944,970.00	- 2,944,970.00
11	Залруулсан үлдэгдэл	1,012,811,105.36						2,062,459,497.06	3,075,270,602.42
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							555,305,956.40	555,305,956.40
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт						884,650,940.70		884,650,940.70
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				870,556,471.43				870,556,471.43
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,012,811,105.36			870,556,471.43		884,650,940.70	2,617,765,453.46	5,385,783,970.95

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,904,381,532.04	3,668,379,614.59
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,695,013,131.04	2,598,226,649.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		15,646,510.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	209,368,401.00	1,054,506,455.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,507,488,484.23	3,335,835,091.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	781,938,431.00	996,210,013.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	170,500,992.20	237,996,244.34
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	72,472,984.00	101,836,075.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,744,894.33	37,449,329.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	65,327,084.30	290,568,712.67
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	73,943,418.40	113,343,974.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	319,560,680.00	1,558,430,741.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	396,893,047.81	332,544,522.98
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,779,952.65	36,614,213.91
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	22,779,952.65	36,614,213.91
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,292,420.00	73,860,447.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,232,420.00	73,860,447.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	12,060,000.00	
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,487,532.65	- 37,246,233.09
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	398,380,580.46	295,298,289.89
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	821,320,837.57	1,219,701,418.03
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,219,701,418.03	1,514,999,707.92

4.5 Аудит хийсэн Зорилтот түвшний биелэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн өссөн дүн		Өөрчлөлт	
			2018 оны тодотгосон төлөвлөгөө /2018.10.16/	гүйцэтгэл	2018 оны төлөвлөгөөнөөс	хувь
1	Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт	мян.төг	598,000.0	690,809.8	92,809.8	116%
2	АЗЗА компаниудын техник, технологийн хяналт	мян.төг	708,666.0	666,511.7	- 42,154.3	94%
3	Лабораторийн сорил шинжилгээний ажил, тоног төхөөрөмжийн түрээс, замын чанар, байдлын судалгаа, дүгнэлт	мян.төг	255,000.0	282,946.1	27,946.1	111%
4	Техник ашиглалтын түвшин тогтоох ажил	мян.төг	277,326.0	53,842.7	- 223,483.3	19%
5	Хөдөлгөөний эрчмийн судалгаа	мян.төг	110,000.0	110,000.0	-	100%
6	Эрдэм шинжилгээ судалгаа, стандарт, норм дүрэм боловсруулах	мян.төг	30,000.0	310.0	- 29,690.0	1%
7	Зураг төсөл төсвийн экспертизийн үйл ажиллагаа	мян.төг	163,000.0	472,208.8	309,208.8	290%
8	ТХЦэгээс ЗХЗ, бусад орлого	мян.төг	267,724.0	451,386.8	183,662.8	169%
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН		2,409,716.0	2,728,015.7	318,299.7	113%
1	Үндсэн цалин	мян.төг	943,082.0	942,052.5	1,029.5	100%
2	Нэмэгдэл	мян.төг	219,524.0	120,859.6	98,664.4	55%
3	Унаа хоол	мян.төг	88,194.0	46,122.0	42,072.0	52%
4	НДШ	мян.төг	150,096.0	132,972.6	17,123.4	89%
	Нийт цалингийн зардал		1,400,895.9	1,242,006.7	158,889.3	89%
1	Бичиг хэргийн зардал	мян.төг	8,502.0	8,356.1	145.9	98%
2	Халаалт, дулаан	мян.төг	10,906.5	6,689.8	4,216.7	61%
3	Цахилгааны зардал	мян.төг	11,830.0	9,494.4	2,335.6	80%
4	Хог хаягдлын зардал	мян.төг	4,350.0	3,891.7	458.3	89%
5	Шатахууны зардал	мян.төг	74,688.5	73,740.6	947.9	99%
6	Шуудан, холбооны зардал	мян.төг	10,144.4	6,210.8	3,933.6	61%
7	Дотоод албан томилолт	мян.төг	72,139.0	68,778.0	3,361.0	95%
8	Гадаад албан томилолт	мян.төг	26,400.0	18,916.0	7,484.0	72%
9	Зар сурталчилгааны зардал	мян.төг	21,600.0	14,996.1	6,603.9	69%
	4000 м2 талбай бүхий хашааны хог хаягдлыг цэвэрлэх зайлуулах	мян.төг	10,000.0	-	10,000.0	0%

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

10	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	13,071.2	12,995.7	75.5	99%
11	Аж ахуй, дотоод хэрэгцээний зардал	мян.төг	9,600.0	9,418.3	181.7	98%
	Түүхий эд материалын зардал	мян.төг	9,450.0	9,351.8	98.2	99%
12	Урсгал засвар, сэлбэгийн зардал	мян.төг	34,240.0	31,913.6	2,326.4	93%
13	Төлбөр хураамжийн зардал	мян.төг	13,980.0	9,438.5	4,541.5	68%
14	Түрээсийн зардал	мян.төг	21,200.0	20,683.9	516.1	98%
15	Сургалт семинарын зардал	мян.төг	21,500.0	20,567.3	932.7	96%
16	Нэг удаагийн тэтгэмж, шагналын зардал	мян.төг	20,800.0	21,323.5	- 523.5	103%
17	Ахмад настан, баяр ёслол, спортын арга хэмжээний зардал	мян.төг	25,505.3	22,158.1	3,347.1	87%
18	Газрын төлбөр	мян.төг	1,770.2	864.3	905.9	49%
19	Автомашинтай холбогдон гарах татвар, даатгал	мян.төг	5,205.0	2,589.7	2,615.3	50%
20	Төсөл арга хэмжээ үйл ажиллагааны бус бусад зардал	мян.төг	314,380.1	126,436.5	187,943.7	40%
21	Аудитын зардал	мян.төг	7,000.0	10,000.0	- 3,000.0	143%
22	Элэгдлийн зардал	мян.төг	241,038.3	355,818.5	- 114,780.2	148%
	Цалингаас бусад зардлын дүн		989,300.5	864,633.1	124,667.4	87%
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		2,390,196.4	2,106,639.8	283,556.7	88%
	ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ		19,519.6	621,376.0	- 601,856.4	3183%
	Орлогын албан татвар	мян.төг	1,951.9	66,070.0	- 64,118.1	3385%
	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ		17,567.7	555,306.0	- 537,738.3	3161%
	Хөрөнгө оруулалт		239,492.2	238,519.9	972.3	100%

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/133/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Татварын ерөнхий газрын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/2653 тоот албан бичигт "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 6.2-д заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх" гэснийг хэрэгжүүлээгүй, 113.8 сая төгрөгийн "Нэмэгдсэн өртгийн албан татвар"-ыг тайлагнаагүй байна.		Албан шаардлага өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Р.Буд 3.Золжаргал
2	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 244 дүгээр тушаал болон ТӨБЗГ-ын 2018 оны 12 сарын 06-ны өдрийн А-4/4578 тоот албан бичгийн дагуу ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Нямдаваад гадаад томилолтын зардал 1,9 сая төгрөгийг олгосон	1.9	Төлбөрийн акт тогтоох	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Р.Буд 3.Золжаргал
3	Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа Эргэлтийн сүргийн мал амьтадын нас дэвшилтийг тооцоогүй	0.9	Зөвлөмж өгсөн	Ерөнхий нягтлан бодогч	3.Золжаргал
4	Компьютер, техник хангамж дансанд бүртгэх нэр бүхий хөрөнгүүдээс Тавилга эд хогшил дансанд 4 нэр төрлийн 6,4 сая хөрөнгийг хөрөнгийн ангилал	6.4	Зөвлөмж өгсөн	Ерөнхий нягтлан бодогч	3.Золжаргал

	зөрүүлж бүртгэсэн				
5	Нийт авлагын үлдэгдлийн 6% буюу 23 харилцагчийн 25.4 сая төгрөгийг "Тооцооны үлдэгдлийн баталгаа"-аар баталгаажуулаагүй.	25.4	Зөвлөмж өгсөн	Ерөнхий нягтлан бодогч	3.Золжаргал
.	Зөрчлийн дүн	34.6			

